102

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2014 оны 01 сарын 17 өдөр Дугаар А-14 Улаанбаатар хот

"Урт хугацаат своп хэлцлийн журам"-ыг
батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Урт хугацаат своп хэлцлийн журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ

14 0109

Tushaal 2014.doc